



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/112

Чингэс хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар, Баянмөнх сумын сургуулийн барилгын их засвар, Тохижилт үйлчилгээний автомашин авах /Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Биндэр, Дадал, Галшар, Норовлин, Батноров сум, Бэрх тосгон/ ажлуудын сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Л.Бат-Октябрь	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Л.Бат-Октябрь/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

20200312